



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 12 сарын 12 өдөр

Дугаар 686

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол улсын Засгийн газрын 2019 оны "Зөвшөөрөл олгох тухай" 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Кибер халдага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв" улсын төсөвт үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 8 нэрийн 18,745,795.00 (арван найман сая долоон зуун дөчин таван мянга долоон зуун ерэн тав) төгрөгийн балансын үнэ, 4,015,773.47 (дөрвөн сая арван таван мянга долоон зуун далан гурван төгрөг дөчин долоон мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу "Радио телевизийн үндэсний сүлжээ" улсын төсөвт үйлдвэрийн газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. "Кибер халдага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв" улсын төсөвт үйлдвэрийн газрын дарга С.Жавхлан, "Радио телевизийн үндэсний сүлжээ" улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал Ж.Энхбат нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх, хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг бэлгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ
137002813
29-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого-зохицуулалтын газрын
2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн
186 дугаар тогтоолын хавсралт

”КИБЕР ХАЛДАГА, ЗӨРЧИЛТЭЙ ТЭМЦЭХ НИЙТИЙН ТӨВ” УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД
БҮРТГЭЛТЭЙ, РАДИО ТЕЛЕВИЗИЙН ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ” УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАРТ БАЛАНСААС БАЛАНСАД
ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Дд	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ (ширхэг)	Нэгжийн үнэ (төгрөг)	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Хувцасны шүүгээ	2/29/2024	1	675,000.00	675,000.00	101,250.00	573,750.00
2	Ширээ	11/7/2023	2	360,000.00	720,000.00	156,000.00	564,000.00
3	Жижиг шкафтай ширээ	11/7/2023	1	800,000.00	800,000.00	173,333.29	626,666.71
4	Модон шкаф	11/7/2023	1	393,000.00	393,000.00	85,150.00	307,850.00
5	Ширээ / 150*50*75/	12/24/2023	15	398,591.00	5,978,865.00	1,096,125.26	4,882,739.74
6	Компьютерын сандал	12/24/2023	50	88,000.00	4,400,000.00	1,344,444.42	3,055,555.58
7	Хурлын ширээ	12/24/2023	1	1,848,000.00	1,848,000.00	338,800.00	1,509,200.00
8	Оффисын ширээ	12/24/2023	10	393,093.00	3,930,930.00	720,670.50	3,210,259.50
НИЙТ ДҮН			81		18,745,795.00 (арван найман сая долоон зуун дөчин таван мянга долоон зуун ерэн тав)	4,015,773.47 (дөрвөн сая арван таван мянга долоон зуун далан гурван төгрөг дөчин долоон мөнгө)	14,730,021.53 (арван дөрвөн сая долоон зуун гучин мянга хорин нэгэн төгрөг тавин гурван мөнгө)